



Э-ТРАНС ЛОГИСТИКС ХУВЬЦААГ КОМПАНИ

Дорноговь аймаг, Заман-Үүд сум, 1-р баг, 10-р хэсэг
Утас/Факс: 02524543813, <http://www.etr.mn>

2020.04.08 № 20-04-28
таниг _____-ны № _____-т

/ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ /
ТӨХК-НД

/ Хүсэлт хүргүүлэх тухай /

Тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 03 сарын 13-ны өдрийн эчнээ хурлын № 02 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 29-ний өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Тусгаар тогтнолын ордны хойд талд City Tower зочид буудлын 25-р давхар дахь хурлын өрөөнд хуралдуулахаар шийдвэрлэсэн билээ.

Улс оронд үүссэн онц байдлын улмаас Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг биет байдлаар зохион байгуулах боломжгүй болж Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу цахимаар хуралдуулан холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр зохион байгуулалтын ажлыг хийж эхэлж байна.

Иймд тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард зарим өөрчлөлт орсон тул энэхүү зарыг Хөрөнгийн биржийн сайтад байршуулан манай ажилд туслана уу

ХҮНДЭТГЭСЭН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.АМАРСАНАА



"Э-ТРАНС ЛОЖИСТИКС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монгол улсын засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны 102 тоот тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан "Э-транс ложистикс" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр 10:00 цагт** цахимаар явагдах болсныг мэдэгдэж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах;
2. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт;
3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
5. ТУЗ-ийн 2020 оны цалин урамшууллын төсөв батлах;
6. Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр:
2020 оны 04 сарын 06-ны өдөр

Хувьцаа эзэмшигчид харилцах ҮЦК-иараа дамжуулан саналаа өгөх боломжтой бөгөөд саналын хуудсаар санал авах хугацаа **2020 оны 04 сарын 28-ны 17:00 цагт** дуусна.

Хувьцаа эзэмшигчид хурлын материал болон хуралд цахим хэлбэрээр хэрхэн оролцож санал өгөх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комисс болон дараах и-мэйл хаягаар тодруулна уу.

Хурал зохион байгуулах комисс: 90999494, 99991451, 99902873

И-мэйл: etranslogistics999@gmail.com

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС